

З.ФРОЙДЫН ПСИХОАНАЛИЗ ДАХЬ УХАМСАРГҮЙ ХЭМЭЭХ ОЙЛГОЛТ

*Р. Дарьхүү (Доктор Ph.D)
Философи, шашин судлалын тэнхим, МУИС
С. Хишигтогтох (Докторант)
Нийгмийн ухааны тэнхим ХовдИС*

Түлхүүр үг: Түрэхүй, эсэргүүцэхүй, түрэгдсэн хүсэл, орлуулахуй, либидо

Товч утга: Психоанализийн эцэг гэдгээр нь З.Фройдг олон хүн мэддэг. Монголчууд Фрейд гэдэг ч герман хэлээр Фройд гэж дуудагддаг тул Фройд гэж бичих нь зөв. З.Фройд «Психоанализ» хэмээх нэр томъёог анх шинжлэх ухаанд оруулсан. Тэрээр “Психоанализ”, “Зүүд нойрыг тайлбарлахуй», «Ердийн амьдралын психопатологи», «Сексийн шинж чанарын тухай онол» «Нэгэн хийрхлийн түүхээс», «Леонардо Да Винчи», «Шүтээн ба хориг» зэрэг олон алдартай бүтээл туурвижээ.

З.Фройдын психоанализ нь А.Адлер, К.Юнг, О.Ранк, К.Абрахам, Э.Жоунс, К.Хорни, Э.Фромм зэрэг эрдэмтэдийг нэгтгэсэн. Неврозыг эмчлэх З.Фройдын арга нь бие хүн ба түүний хөгжлийн тухай үзэл баримтлал болон өргөжжээ. Үүнтэй холбогдуулан “Бидний ухамсарт байдаг далд ертөнцийг нээж өгсөнд нь бид З.Фройдод бүх л талаар өртэй юм» хэмээн нэгэн эрдэмтэн бичсэн байдаг. З.Фройд бүхий л амьдралынхаа туршид өөрийн психоанализаа улам бүр боловсронгуй болгож байжээ. 1908 онд Зальцбург хотноо психоаналитикчдийн анхдугаар их хурал хуралдаж, 1909 онд психоанализийн олон улсын сэтгүүл гарч эхэлсэн байна. 1920 онд Берлинд психоаналитикийн анхны дээд сургууль нээгдэн, дараа нь Вена, Лондон, Будапешт, Нью-Йорк, Чикаго зэрэг хотод мөн ийм сургуулиуд байгуулагджээ. 1923 онд З.Фройд хүндээр өвчилж, олон удаа хагалгаанд орсон боловч өвчнөө үл тоон идэвхтэй ажиллаж байсан гэдэг.

З.Фройд хүний үйлдлийн тодорхой хэсгийг удирдаж байдаг ухамсаргүйг “Ид” хэмээх ойлголтоор илэрхийлжээ. “Ид” нь хүний амьдрал, үйл ажиллагаанд ямагт оролцож бидний үйл үйлдэл, зан байдлын олон төрлийг удирдаж байдаг төдийгүй нийгэм, соёлын ертөнцөд “Ид” - ийн үүрэг их байдаг гэсэн баримтлал энэ онолын гол агуулга нь болдог. Тэрээр хүнийг тайлбарлах өөрийн үзэл санааны хоёрдмол шинжээрээ

бусад сургаалиас ялгарч нийгэм, соёл, бие хүний хямралын шалтгааныг сэтгэц задлан шинжилгээний онол, ухамсаргүйн үүднээс тайлбарлах болсон нь уламжлалт философийн хүнийг үзэх үзлээс эрс өөр хандлагыг үндэслэн хүнийг ойлгох урьдын төсөөллийг шинэ шатанд аваачиж чадсан.

Бид энэ өгүүлэлд ухамсаргүй нь хүний үйлдэлд хэрхэн оролцож байдаг, ухамсаргүй нь ухамсар, ухамсрын дээд эрэмбэ болох супер-эготой ямар хамааралтай болох, ухамсаргүйн дүрээ хувиргасан орлон тоглогч нь хүний санаатай, санамсаргүй үйлдэлд хэрхэн хэрэгжиж байдаг тухай асуудлыг авч үзэв.

Ухамсаргүй хэмээх ойлголтын тухайд. Сэтгэц задлан шинжилгээний онол ёсоор өөрийнх нь тусламжтайгаар өвчтнийхөө оюун санааны гүн рүү нэвтрэн орж, хүний сэтгэл хямралын шалтгаан болсон туршлагын мэдрэмжийг илрүүлж болно гэж тэрээр нотолдог. Хүний ухамсартай үйлдэл биш, харин өөрөө ухамсарлаж чадахгүй байгаа үедээ хар аяндаа ярьж буй үг, үйлдэл хүний сэтгэцэд нуугдмал байдлаар оршин байгаа янз бүрийн сэтгэцийн зөрчилтэй үйл явдлуудыг илрүүлэн гаргахад хамгийн гол түлхүүр болно гэж З.Фройд үзсэн юм. Өөрөөр хэлбэл хүний ухамсарын хүчээр түрэгдэн ухамсаргүйн гүнд хаягдсан аливаа сэтгэцийн үзэгдлүүд нь “субъект” ухамсрын хяналтаа алдсан үед (сэтгэцийн хурц

хямралын үе, зүүд нойрондоо, мансууруулах бодис хэрэглэсэн эсвэл амь дүйсэн эгзэгтэй үед) илрэн гардаг гэж үзсэнд энэ онолын гол үзэл санаа оршдог. Тэрээр хүний уг чанар болон хүний ухамсраас муу бодлыг шахан зайлуулдаг сэтгэцийн механизмын талаар гүнзгийрүүлэн судалсан нь хүнийг ойлгох философи ойлголттой холбогдоход хүргэжээ.

З.Фройдын үзлээр, ухамсаргүй бол хүний сэтгэлийн бие даасан, ухамсраас хараат бус зүйл юм. Ухамсаргүйн тухай үзэл санаа бол психоанализийн хөгжлийн үе шат бүхэнд гол судлагдахуун нь болж ирсэн. Тэрээр судалгааныхаа эхэн үед “Ухамсаргүй” гэдгийн дор зөвхөн гадаад орчноос юмуу дотоод сэрэл хүртэхүйгээр дохиолол байдлаар хүний ухамсарт мэдрэгдэн хүртэгдээд ухамсарт түрэгдэн ухамсаргүйн бүсэд хоригдсон санаа бодол, дур, хүслийг ойлгож байлаа. Эдгээр нь ухамсарлагдаж, эсэргүүцэлтэй тулгарах үед хувь бодгалийн сэтгэцийн талбарт зөрчил үүсдэг. Энэхүү ухамсарт ба ухамсаргүй сэтгэцийн зөрчил нь хүчтэй болж ирэхэд “Истери” буюу хий хөөрүү өвчний шинж тэмдэг биежих шалтгаан болдог гэж тэрээр үзэж байв. Хувь хүний сэтгэцийн үйл ажиллагааг З.Фройд дайны талбартай зүйрлэсэн. Тэрээр 1909 онд АНУ-д уригдан ирж уншсан лекцдээ “Хий хөөрүүтэй хүмүүс маань ой дурдатгалын нөлөөгөөр тарчилж байдаг юмаа л гэж томъёолон хэлэх байна.¹... “Хий хөөрүүгийн зовнилын үед бодгалийн ямар нэгэн хүслэн, бусад үзэл бодолтой нь гүнзгий зөрчилд орсон, бие хүний ёс суртахуун, гоозүйн үзэл бодолтой эрс “харшилсан” тийм нэгэн хүсэл төрдөгт л хэргийн учир байгаа юм² гэжээ.

З.Фройд хий хөөрүү өвчний шалтгааны талаар ийм нэг жишээ татсан байдаг. “Нэгэн залуу бүсгүй өвчтэй эцгээ сахиж байгаад өөд болгож л дээ. Тэр бүсгүйн том эгч дөнгөж саяхан нэг хүнтэй суусан байв. Гэтэл нөгөө бүсгүй хүргэн ахдаа нэлээд сэтгэлтэй болчихсон бөгөөд түүнийгээ төрсөн ах дүү ёсны хайр энхрийллээр халхавчлаад яваад байж болдог байв. Гэтэл эгч нь бүсгүй дүү, эх хоёроо байхгүйд нь өвчилж байгаад нас

баржээ. Тэднийг яаралттай ирэхийг дуудсан байна. Хүүхэн ирчихээд талийгаачийн ор луу явах зуураа одоо тэр чөлөөтэй, надтай сууж болох юм гэсэн хэдэн үгээр ойролцоогоор илэрхийлж болох утгатай зүйлс бодогдсон байна. Хүргэн ахдаа сохроор дурласныг нь ухамсарт хүргэж буй энэ үзэл бодол бүсгүйн уй гашуу хүчтэй гадагшилсан яг эхний мөчид дахин “түрэхүйд” өртөж байгаа юм. Ингээд нөгөө хүүхэн өвчин тусч, хий хөөрүүгийн шинж хүчтэй ажиглагдаж эхэлсэн.³ гэжээ.

Энэ жишээний хувьд бүсгүй сэтгэц задаргааны нэршлээр бол неротик түгшүүрт автсанаас үүдэн сэтгэцийн хурц хямралд хүрсэн. Невротик түгшүүр гэдэг нь уг онолд “Хяналтанд баригдаж захирагдахааргүй ухамсаргүй хүсэл эгод заналхийсэн үед хувь хүнд айдсын хэлбэрээр илэрч буй сэтгэл хөөрлийн хариу үйлдэл. “Ухамсаргүйгээс”-ээс ирж буй ямар ч хяналтгүй хөөрөл эвгүй байдалд оруулчих вий дээ гэж эмээх сэтгэл⁴ буюу энгийн үгээр бол өөрөө өөрөөсөө айх, «өөрийгөө хяналтгүй юу л хийчих бол» гэсэн түгшүүр юм. Жишээ нь хулгай хийх нь буруу гэдгийг хүн мэдсээр байгаад л хулгай хийж, бүтэхгүй гэдгийг мэдсээр байгаад дурлах, авлига авах нь хортой гэдгийг мэдсээр байгаад шунах энэ бүхэн ухамсарт баригдахгүйгээр /өөрийн эрхгүйгээр гэж бид ярьж заншсан/ үйлдэлд илэрч буй ухамсаргүй дур хүслийн хүч юм. Энэхүү дур хүслийг хязгаарлаж ухамсаргүй руу дарж байгаа хүч бол ухамсраас үүдэлтэй ёс суртахууны эмээх мэдрэмж мөн.

Ухамсаргүй Ид ба ухамсар Эго-гийн хамгааллын механизм. Хүний ухамсаргүйд хадгалагдсан аливаа дур хүсэл ухамсарлагдаж ханамж авахыг ямагт эрмэлзэж байх ба ухамсар түүнийг үргэлж хянаж байдаг. Ухамсар хянаж байгаа хэдий ч ухамсаргүй түүнийг ямагт шаналгаж амар тайван байлгахгүй. Тиймээс ухамсар “Аюул ихтэй зүйлээс аюул багатай зүйл рүү зөн билэгт “Ид” - ийн түлхцийг шилжүүлэн илэрхийлэх явцад ухамсрын буюу эго-гийн хамгааллын механизм хэрэгжддэг⁵ Эго-гийн хамгааллын механизмын нэг хэлбэр бол орлуулахуй юм.

¹ Фрейд З. Психоанализ. Орч. Баяртогтох М. УБ., 2001. 17 дахь тал

² Collection of six freud's lectures in states. New York. 2010. P. 46

³ Фрейд З. Психоанализ. Орч. М.Баяртогтох. УБ., 2002. 28-29 дэх тал

⁴ Мөн тэнд. 31 дэх тал

⁵ Бие хүний онол дахь психодинамик чиг хандлага. Орч. Мягмар О. УБ., 2001. 41 дэх тал

Орлуулахуй нь хүүхдэд ч илэрч байдгийн нэгэн жишээг З.Фройд авч үзсэн. Нэг нас таван сартай, хөхөөрөө хооллодог балчир хүүгийн үйлдлийн учрыг олтлоо мөнөөх хүүхэд, эцэг эхтэй нь нэг дор хэдэн долоон хоног хамт байсныхаа эцэст ээжийгээ удаан орхиж явдагт дургүйцсэн хүү дургүйцлээ тоглоомоор орлуулан тоглох байдлаар түүнээсээ ханамж авдаг болохыг ажигласан нэгэн тохиолдлыг авч үзсэн байна. “Алдрайхан хүү гартаа таарсан жижиг сажиг юу л байнав өнцөг булан орон доогуур хамаа намаагүй цацдаг байсан... ингэж ахуйдаа тэр хүү их сэтгэл ханамжтайгаар о-о-о-о-о хэмээн чангаар үргэлжлүүлэн орилох бөгөөд үүнийг ээжийнх нь хэлснээр зүгээр ч аялга биш “зайл” (fort) утгатай аж. Хүү тарааж хаях, цацах мэтчилэнгээр тоглохын тулд энэ тоглоом байдаг, тоглоомоо зөвхөн үүнд л зориулдаг юм байна гэдгийг ажигласан. Нэг удаагийн ажиглалт минь энэ бодлыг батлав. Хүү модон дамар бариад, дамраа утаснаас нь барьж байгаад орныхоо торны цаагуур далд ортол сурмаг чулуудчихаад нөгөө олон утгат о-о-о-о-о-о-о гоо аялгуулж байгаад дамраа утаснаас нь татаж гаргахдаа арай өөрөөр Да (Тэр) дуу алдав. Хоёрдох явдал гарцаагүй ханамж өгсөн явдал болов. Эх орхиод явахад үүссэн зовиурт сэтгэлгээгээ хүүхэд тоглоомын хэлбэрээр даван гарч буй нь ханамжийн зарчимтай хэрхэн зохицолдож байна. Эх яваад эргэж ирэх нь баярт явдал, энэ тоглоомын эцсийн зорилго, дамраа утаснаас нь татаж гаргахдаа арай өөрөөр Да (Тэр) гэж дуу алдах нь эхийг эргэн эрж буйгаар орлуулж “ээж- тэр ирлээ” гэсэн санааг илэрхийлж буй юм.⁶ Эхийг эргэж ирэхийг хүлээсэн хүүхдийн ухамсаргүй хүслийг тоглоомоор орлуулах байдлаар ухамсаргүй дахь халхлагдсан хүслээ илэрхийлсэн ханамж авах үйл явц мөн.

“Тоглоомоо цацаж алга болгож байгаа нь хүүхдээ орхиод явсан ээждээ өшөөрхсөн нэгэн дарагдсан хүслийн биелэл, “яв”, “зайл гэм”, та надад хэрэггүй, би өөрөө таныг хөөж байна хэмээн зөрүүдлэж байж болох аж.⁷ Биднээс энд дурдан буй тохиолдолд хүүхэд тоглоомоороо зохимжгүй сэтгэгдлээ илэрхийлж чадах бөгөөд үүнтэй нь өөр

нэгэн зүйл тухайлбал, шууд ханамж холбоотой юм. “Хүүхэд амьдралд хүчтэй сэтгэл төрүүлсэн юм бүхнийг тоглоомоороо давтдаг, ингэснээрээ тухайн сэтгэгдлийнхээ хүчийг зохицуулж бүр нөхцөл байдлын “ээд” нь болсон мэт байдгийг байнга ажиглаж болно.⁸ гэж З.Фройд тайлбарлаж байв.

Нас биед хүрсэн хүмүүс ч гэсэн ухамсаргүйгээр эвгүй үнэрт дурлах, ямар нэг зүйлд донтох, ямар нэг зорилгогүй эвдэн сүйтгэх гэх зэрэг ухамсаргүйдээ захирагдсан байдлыг харуулдаг. Ухамсаргүйн илрэл бүхий авир үйлдлийн садист, мазохист шинжүүд нь халхлагдсан хэлбэрээр ухамсарт довтолж хүний үйлдэлд оролцдог. Энэ нь сэтгэц задлан шинжилгээний ойлголтоор бол “орлуулахуй”⁹ – н жишээ юм. Ийнхүү хүний ухамсаргүйн хүрэн дэх дарагдсан сөрөг хүсэл, үзэл бодлоо дам байдлаар гүйцэлдүүлэхдээ “орлуулах” үйлдлийг хэрэглэдэг байна. Энэ нь “аюул ихтэй зүйлээс аюул багатай зүйл рүү зөн билэгт “Ид”-ийн түлхцээ шилжүүлэн илэрхийлэх явцад илрэх хамгааллын механизм”¹⁰ - ын нэг хэлбэр юм. Жишээ нь, хэт өндөр шаардлагатай даргадаа шүүмжлүүлсэн эмэгтэй нөхөр хүүхдүүдийнхээ өчүүхэн төдий эсэргүүцлийг хилэгнэн хүлээж авах¹¹, эдгээр жишээ нь жинхэнэ хандах ёстой зүйлийнхээ оронд хүн өөртөө аюул багатай, зүйлийг орлуулсныг харуулж байна.

З.Фройд үзэхдээ, “Бид уг ухамсаргүй буюу дур хүслээ хангах зарчмыг насанд хүрэх хүртлээ цаашлаад амьдралынхаа туршид өөртөө авч явдаг. Гэхдээ аажмаар бид өөрсдийн хүслээ хянаж, хүрээлэн буй орчинд тохируулж нийцэж сурдаг.”¹² гэж үзсэн.

Бид бас ухамсаргүйд дарагдсан Ид-ийн хүслээ халхлагдсан байдлаар илэрхийлж тайвшрах, таашаал авах өөр нэгэн хэлбэрийг сэтгэц задлан шинжилгээний онол “проекти” гэсэн ойлголтоор илэрхийлдэг. “Проекц”-ыг хэрэгжүүлэхдээ зүйд үл нийцэх өөрийн далд ухамсаргүйдээ дарах гэсэн мэдрэмж, сэтгэгдэл, санаа

⁸ Мөн тэнд.

⁹ Фрейд Зигмунд. Пять лекций о психоанализе. СПб., 1999. Алетейя. С 136

¹⁰ Там же. с138

¹¹ Там же. с139

¹² Фрейд З. Психоанализ. Орч. М.Баяртогтох. УБ., 2002. 26 дахь тал

⁶ Фрейд З. Ухамсаргүйн чинадад. Орч. М.Баатартогтох. УБ., 2015. 17 дахь тал

⁷ Мөн тэнд. 18 дахь тал

бодол, зан үйлээ орчиндоо болон бусдад нялзаах байдлаар илэрхийллэгддэг байна. Жишээ нь “Бэлгийн хүчтэй дур хүсэлтэйгээ тэмцэж байгаагаа өөрөө ухамсарлахгүй байгаа залуухан эмэгтэй тааралдсан хүн бүрийг миний толгойг эргүүлэх гэж байна гэж хардаж байгаа явдал бол проекцийн жишээ.¹³ Энэ жишээ бол бэлгийн дур хүсэлдээ автсан байгаагаа хүлээн зөвшөөрөхгүй хүн бусад хүний бэлгийн амьдралд ихээхэн уурсаж мэднэ.

Бид хэн нэгний нэрийг мартдаг, бид ярьж байхдаа хувцсаараа оролдож байдаг, бид заримдаа үг хэлэхдээ гацаж, эсвэл гэмгүйхнээр хэл хальтирах нь бий. З.Фройдынхоор хэл хальтирах буюу андуурч ярих нь бидний бодож байгаа шиг гэмгүй эсвэл санамсаргүй зүйл биш аж. Бид төлөвлөлгүй юм хийж, хэлдэг (ярих, сонсохын зэрэгцээ ямар ч зорилгогүйгээр юм эвдэх, оролдох жишээ нь балаа хазах, ширээн дээр элдэв зүйл эрээчих гэх мэт) нь Ид-ийн ухамсарлагдаагүй түлхцүүдтэй холбоотой. “Ухамсаргүйн хариу үйлдлүүд бидний мэдрэмж, үйлдлүүдийг сэдэж байдаг. Энэ нь түүний нэрлэснээр “Парапраксис” буюу “хэл халтирахуй юм. Өөрөөр хэлбэл бид нэг удаа дарахыг хичээсэн зүйлээ санаандгүй хэлэх эсвэл хийж орхидог.

Түүний үзсэнээр “Хүний хийж байгаа зүйл утгатай шалтгаантай, зорилготой, ялихгүй гэж санагдаж байгаа үйлдэл, үйл явдлууд бүгд дотоод шалтгаантай. Тийм учраас хүний хошигнол, алдаатай үйлдэл, санаандгүй яриа, егөөдөл болгон цаанаа өвөрмөц шалтгаантай байдаг.¹⁴ Бодит нөхцлийн зарчимд илэрхийлэгдэх боломжгүй янз бүрийн хүсэл тэмүүлэл, айдас түгшүүр, зэвүүцэл, жигшил, гоморхол ухамсаргүйн хүрээнд дарагдаж байгаад дүрээ хувирган хүний зан үйлийн илэрхийлэл болдгийн илэрхий жишээ бол хэл халтирах, хошигнол, егөөдөл зэрэг юм. Өөрөөр хэлбэл, бид нэг удаа дарахыг хичээсэн зүйлээ санаандгүй хэлэх эсвэл хийж орхидог аж.

Хошигнол, егөөдөл, хэл халтирах зэрэг нь шалтгаантай гэж үзсэнийг товч тайлбарлая. Хошигнол, егөөдөл, алдаатай

үйлдэл, хэл хальтирах нь гадаад ертөнцөөс хүртэгдсэн юм уу эсвэл хүний дотоод түлхэц “Ухамсаргүй”-н дохиоллоор ухамсарт ямар нэг хэмжээгээр өгөгдөөд бодит нөхцөлийн зарчимд хүлээн зөвшөөрөгдөөгүйн улмаас түрэхүйд өртөж ухамсаргүй рүү дарагдсан янз бүрийн бодол, хүсэл нь эргээд хүний үйл ажиллагаанд дам байдлаар оролцохдоо дүрээ хувиргасан хэлбэрээр илэрхийлэгддэг гэнэ. Хэл хальтирч хэлсэн үгийг бодит амьдрал дээр бодож боловсруулсан үгнээс “аюулгүй” мэтээр хүлээн авч “санаандгүй” хэлсэн хэмээн цайруулж ойлгодог.

Харин З.Фройдын психоанализ дахь ухамсаргүй ойлголтоор энэ нь далд шалтгаан агуулдаг. Монголчууд хэлэх гэж хэлэв үү?, хэл хальтираад хэлэв үү гэж ярьдаг. З.Фройдын үзлээр, хэлэх гэж хэлсэн үг нь ухамсартайгаар бодож боловсруулсан зорилго чиглэлтэй хэлсэн үгийг тусгадаг бол, хэл хальтираад хэлсэн үг нь ухамсаргүй рүү түрэгдсэн хүний хүлээж авч боломгүй “аюултай”, “ичгүүртэй” гэж үзэгдэх шалтгаан агуулсан үг байх нь. Энэ утгаар нь авч үзвэл хэл хальтираад хэлсэн үг нь хэлэх гэж хэлсэн үгнээс ч “аюул” ихтэй байдаг.

З.Фройд үүний жишээ болгож эзэндээ зориулж хундага өргөх болсон дэлгүүрийн даамлыг жишээ болгосон байдаг. “Эзэн нь олонд нэр хүндгүй, энгийнээр хэлэхэд түүнийг гахай гэж дуудаж болохоор өөдгүй хүн байлаа. Даамал босоод, хундагаа өргөж “үүнийг гахайд зориулж байна” гэчихэж. Тэр үнэндээ хэлчихмээр байдаг үгээ л хэлчихсэн юм. Гэхдээ тэр үүнийг хэлье гэж бодоогүй аж.¹⁵

Өөр нэгэн тохиолдол бол шог, хошин шог үг хэллэг юм. “Их ёсорхуу биш хоёр эр хэдэн үйлдвэрлэл зоримогоор хэрэгжүүлж ихээхэн хэмжээний өв зоорьтой болж л дээ. Дараа нь дээдсийн хүрээлэлд орохын тулд тун ч их хичээл зүтгэл гаргасан гэнэ. Тэрхүү хичээл зүтгэлийн нэг нь хамгийн эрхэм алдартай зураачаар хөргөө бүтээлгэх учиртай байжээ. Тэгээд их том үдэшлэг зохиож, их үнээр хийлгэсэн зургаа анх удаа нийтийн өмнө тавьж үзүүлжээ. Зочны өрөөний хананд байрлуулсан зургаа харуулж бүрэн хэмжээгээр сайшаасан санал, шагшсан үнэлгээ дуулах гэсэндээ

¹³ Жостейн Гаардер. Софийн ертөнц. Орч. Б.Мөнхжавхлан. УБ., 2013.

¹⁴ Батболд Ш. Сэтгэл судлал, сонгодогууд. УБ., 2010. 225 дахь тал

¹⁵ Батболд Ш. Сэтгэл судлал, сонгодогууд. УБ., 2010. 29-30 дахь тал

бас нэг маш нөлөөтэй, урлагийг гоц сайнаар мэддэг судлаачийг урьж иржээ. Судлаач хөргүүдийг харж, харж ямар нэг юм дутуу орхичихжээ гэсэн аятай толгойгоо сэгсэрч байснаа хоёр хөргийн хоорондох хоосон зайг зааж “and where is the Saviour” / ингэхэд нөгөө авралт нь хаана байна вэ? Христосыг хэлж байна/ гэж асуусан байна. Урлагийн гоц шинжээч: та хоёр хоёулаа л дээрэмчин л дээ, та нартай адилхан юмсын дунд авралтыг цовдолсон юм биш үү гэж хэлэх гэсэн санаа юм. Тэрбээр яг ингэж хэлээгүй, шууд ингэхийн оронд тухайн тохиолдолд ерөөс падгүй зүйлийг өгүүлсэн нь гаргах гэсэн басамжлангүй санаагаа ойлгуулах гэсэндээ битүү дохио санамж хаясныг дээрх үгнээс мэдэж болно гэжээ.¹⁶ Энэ дохио санамж хэлэх гэсэн боловч шууд хэлчихээргүй дотоод санаа бодлынх нь “орлогч” болох юм. Шүүмжлэгч хэлэх гэсэн санаагаа шууд хэлчих нь түүний ёс зүй, бодит нөхцлийн зарчимд харшилж, эсэргүүцэлтэй тулгарч байсан нь орлогч” явуулахад хүргэсэн байна.

Эдгээр будлиантай алдаатай үйлдэл нь бидний хамгийн гүнээ нуусан нууцуудыг илчилж байдаг гэнэ. Энэ талаар З.Фройд хэлэхдээ: “Таагүй зүйлийг ухамсаргүйд дарж орхиж болохгүй, дарж орхисон ч гэсэн хүн өөрийн ухамсаргүйн нөлөөллөөс зугтаж чадахгүй. Энэ нь яг л оготны нүх рүү ус цутгаж бөглөхтэй адил юм. Ус цэцэрлэгийн өөр хэсгээс урсаад гараад ирнэ. Иймд үүнийг ухамсар болон ухамсаргүйн хооронд хаалгыг дутуу хаагаад орхих нь хамгийн тохиромжтой юм.”¹⁷ гэжээ. Энэхүү үзлээр, хэрэв хаалга гүйцэд хаачихвал сэтгэцийн өвчин тусах үндсэн нөхцөл бүрэлддэг болохыг олон жишээ баримтаар З.Фройд тайлбарласан. Түрэгдсэн хүсэл нь ямагт хүний ухамсарт эсэргүүцэлтэй тулгарч байдаг бөгөөд түрэгдсэн хүсэл ба эсэргүүцэл хоёрын хоорондын зөрчил нь хүнд үргэлжийн түгшүүр шаналгааг үүсгэж байдаг гэж тэрээр дурдсан байдаг.

Энэ тухай нэгэн жишээ татсаныг дурдвал, “Та бидний сууж байгаа танхим ямар сайхан намуухан чимээгүй, хүмүүс ч юутай ихэд шимтэн сонсож байгааг магтаад барамгүй. Тэглээ ч гэсэн дэмий

ярьж инээлдэх, шал дэвсэх зэргээр лекцээ үргэлжлүүлэхэд минь саад учруулж буй бодгаль энэ танхимд байна гэж үзье л дээ. Ийм нөхцөлд би цааш үргэлжлүүлж чадахгүйнээ гэвээс та нарын дотроос нэг нь босч нөгөө журам зөрчигчийг хөөгөөд гаргачихлаа гэж төсөөлье.”¹⁸ Энэ бол психоаналитик ойлголтоор бол түрэхүйн жишээ юм. Сэтгэцийн үзэгдлийн хувьд танхимд дүрэм зөрчигч бодгалийн жишээ бол хүн ёс суртахуун, гоо зүй, хүний мөс чанарын үүднээс эсэргүүцэлтэй тулгарч буй муу хүсэл гэсэн үг юм. “Ингээд дэг журам зөрчигчийг түрэн гаргасан учраас би лекцээ үргэлжлүүлэх бололцоотой болох юм гэж та бүхэн ойлгож байгаа. Түрэгдэж гарсан этгээд танхимд эргэж орохыг эрмэлзэж хөөж гаргасан эрхэмийн эсэргүүцэлтэй тулгарна. Энэ хоёр байрлалыг сэтгэл зүйн хэлээр танхимд ба түүний гадна, ухамсартай ба ухамсаргүй гэж нэрлэх аваас түрэхүй ба эсэргүүцэхүйн үйл явцыг ойлгож болно”¹⁹ гэсэн байна.

З.Фройд зөрчил гаргагч ухамсаргүйн түлхэц хөөрлийг зайлуулж үүдэнд манаач тавьсанаар асуудал дуусахгүй гэж үзсэн. Нөгөө хөөгдөж гарсан этгээд танхимын гадна айхтар шуугиан дэгдээхтэй адил түрэгдэж ухамсраас гарсан хүсэл нь түрүүчийн нөхцөл байдлаас ч илүү түгшүүр үүсгэж, хүний үйл ажиллагааг үр дүнгүй болгож тавгүйтүүлж байдаг, өөрөөр хэлбэл сэтгэл санааг хямруулж байдаг учир түрэхүй нь тийм ч үр дүнтэй биш гэж тэрээр үзсэн байдаг.

Сэтгэц задлан шинжилгээний онолоор хэрэв хаалга гүйцэд хаачихвал сэтгэлзүйн өвчин тусах, өнөө үеийн ойлголтоор “стресс”-д орох үндсэн нөхцөл бүрэлддэг болохыг туршилтынхаа явцад З.Фройд нотолжээ. Тэрээр “Ухамсарлагдаагүйн тухай үзэл санаа түрэхүйн тухай асуудлаас гарч байгаа юм.”²⁰ гэж үзсэн хэдий ч сүүлийн үеийн бүтээлүүддээ “түрэгдсэн бүх зүйл ухамсарлагдаагүй, гэхдээ ухамсарлагдаагүй бүх зүйлийг түрэгдсэн гэж үзэж болохгүй гэсэн дүгнэлтийг бид хийж байна”²¹ гэжээ. З.Фройд “Бид тэрхүү “Би” - ухамсраас түрэгдсэн юм лүгээ нэгэн

¹⁶ Фрейд З. Психоанализ. Орч. М.Баяртогтох. УБ., 2002 36-37 дахь тал

¹⁷

¹⁸ Фрейд З. Психоанализ. Орч. М.Баяртогтох. УБ., 2002. 29

¹⁹ Мөн тэнд. 30 дахь тал

²⁰ Фрейд З. Зохиолууд. (Би хийгээд тэр /ICH und ES /). Орч. М.Баяртогтох. УБ., 2011. 135 дахь тал

²¹ Мөн тэнд. 138 дахь тал

адил ухамсаргүйгээр илрэн гардаг нэг тийм зүйл байгааг олсон, өөрөөр хэлбэл ухамсарт шилжихгүйгээр хүчтэй үйлдэл үзүүлж байдаг тийм зүйл бөгөөд түүнийг эмчилгээний явцад ухамсарлуулахад онцгой ажилбар шаарддаг билээ²² гэж бичжээ. Тэрээр сэтгэлийн хямралыг ухамсарт түрэгдсэн ухамсарлагдаагүй хоёрын хоорондох зөрчил мэтээр үзэх аваас психоанализийн практикийн нэг л иймэрхүү ажиглалтаас хэтрэхгүй гэж үзсэнээр хүний сэтгэц чанар дахь Ид-ийн шинж байдлын тухай баримлалыг цааш хөгжүүлсэн.

З.Фройд бичихдээ: “Бүхэл бүтэн Би-д /ухамсар гэж ойлгож байна/ түүнээс салан тусгаарлагдсан зүйлийг нь сөргүүлэн тавих хэрэгтэй... Би-гийн нэг хэсэг нь /чухам ямар хэсэг болохыг бурхан л мэдэх хэрэг/ ухамсарлагдаагүй байж болох бөгөөд ер эргэлзээгүй тийм гэдэг нь тодорхой..., өөрөөр хэлбэл түрэгдээгүй ухамсаргүйг хүлээн зөвшөөрөхдөө ухамсарлагдаагүйн мөн чанар бидний хувьд бас анхны ач холбогдолоо алдаж байгаа гэдгийг зөвшөөрөхөөс аргагүй²³ гэжээ. Учир нь З.Фройдын хувьд ухамсаргүйн тухай ойлголтдоо анхандаа зөвхөн ухамсарт хүртэгдээд эсэргүүцэлтэй тулгарч ухамсаргүйд түрэгдэж дарагдсан хүсэл санаа, ой дурдатгалын хэлбэрүүдийг багтааж байсан юм.

Тэрээр түрэхүйд өртөөгүй ухамсаргүйн тухай дүгнэлт нь бидний ашиглахыг хүссэн маргашгүй түгээмэл дүгнэлтийг гаргаж боломгүй олон утгат чанартай болж хувирна гэж дурдсан. Гэхдээ “Түрэгдээгүй ухамсаргүйн тухай асуудлыг орхих нь бэргүүштэй /орхиж боломгүй/, учир юу гэвээс ухамсарлахуйн чанар нь гүний сэтгэцийн манант харанхуйд биднийг цаашид хөтлөх цорын ганц туяат гэрэл бөлгөө²⁴ гэсэн байна.

Тэрээр “гүний сэтгэцийн манант харанхуй” гэж мөсөн уулын ёроол болох Ид-ийн орон байр ухамсаргүйн орон зайг хэлсэн бололтой. З.Фройд “Ухамсар нь сэтгэцийн аппаратын өнгөц давхарга,... орон зайн хувьд гадаад ертөнцөд үлэмж

ойрхон нэг тийм тогтолцооны үүрэг болгочихсон билээ... гаднаас ирэгч бүх хүртэхүй, түүнчлэн дотоод сэрэл мэдрэмж /өтгөн шингэний ялгарал, өлсөх, өвдөх/ бүгд л ухамсарлагдсан байдаг. Гэтэл бид нэлээд хангалтгүй байдлаар сэтгэцийн үйл явц гэж нэрлээд байгаа тэрхүү дотоод үйл явцууд ер чухам юу болоод байна вэ? Аппарат /сэтгэцийг бүхэлд нь хэлж байна гэж ойлгож байна/-ын дотор хаа нэгэнтээ үйлчилж, үйлдэл хийхэд хүргэдэг сэтгэлийн энерги болсон эдгээр процесс ухамсар үүсгэгч гадаргууд хүргэдэг үү? эсвэл бүр эсрэгээрээ, ухамсар тэдэнд бүр өөрөө хүрч үйлчилж байна уу?²⁵ гэсэн асуултанд хариулах хэрэгтэй болсон. Тэрээр ухамсарлагдаагүй гэдэг сэтгэцийн бусад тийм салбаруудыг (Оно) “Es” гэж нэрлэх саналтай байна.²⁶ гэжээ.

“Эдгээр процессууд /үйл явцууд/ сайн мэдэгддэггүй, тэдний хамгийн сайн загвар нь ханамж, эс ханамж гэсэн хоёр байж болох талтай гэж үзсэн. Өөрөөр хэлбэл Ид – ийн энерги ухамсарлагдахаар завдаж байгаа нь шууд мэдрэгдэхгүй, хүний үйл ажиллагааны явцад дам байдлаар оролцож өөрийн ханамжаа гүйцэлдүүлж байдаг.

Үүний тод жишээг Ж.Отгонбаяр нэгэн өгүүлэлдээ тодорхой тайлбар хийснээс иш татвал, “Эрт цагийн хадны сүг зураг ч тэр, эдүгээ цагийн оюутны ширээний бичээс ч тэр ялгаагүй хүний “Ид”-ийн илрэл юм. Хадны сүг зураг бол эртний хүмүүс өөрсдийнхөө ухамсаргүй дэх энергийг шингээж үлдээсэн нэгэн төрлийн символчлол мөн гэж үздэгийн адил эдүгээ цагийн ширээн дээр бичигдсэн текстийг зураачынх нь ухамсаргүйн илэрхийлэл, З.Фройдын нэрлэснээр Ид нь орж барж байж ядан сад тавьсаны ул мөр хэмээн үзэж болохоор санагдана.²⁷ гэжээ.

Психоаналитик үзлээр, бодгаль нь бусад хүмүүсийн хувьд танигдаагүй “Оно /Тэр/” өөрөөр хэлбэл Ид бөгөөд үүний гадаргууд Би-ухамсар оршин буй билээ... Я-Би нь Оно /Тэр/-тэй сэтгэцийн орон зайн хувьд тодорхой хэсгээрээ холбогдсон байна²⁸ гэжээ. Оно-/Тэр/ гэдэг нэр томъёо

²² Мөн тэнд. 139 дэх тал

²³ Мөн тэнд. 130 дахь тал

²⁴ Фрейд З. Зохиолууд. (Би хийгээд тэр /ICH und ES /). Орч. М.Баяртогтох. УБ., 2011. 138 дахь тал

²⁵ Мөн тэнд. 139 дэх тал

²⁶ Мөн тэнд. 143 дахь тал

²⁷ Отгонбаяр Ж.Нэмэхжаргал Т. Ширээн дээрх бичсэн текстийн тухай эрэгцүүлэл. МУИС. ЭШБ, Философи шашин судлал №271(37) УБ., 2007. х 110

²⁸ Фрейд З. Зохиолууд. (Би хийгээд тэр /ICH und ES /). Орч.

нь Ид-ийг илэрхийлж байгаа болохоор энд З.Фройд хүн бол төрөлх чанараараа танигдаагүй Ид байдаг гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, хүн төрөлх чанараараа амьтны маягийн инстинктэй бөгөөд үнэндээ хүнийг ухамсрын хүрээнээс танин мэдэх боломжгүй гэсэн санааг дэвшүүлж байв. “Харин түрэгдсэн зүйл нь Оно /Ид/ - той бас нийлэх боловч түүний нэг хэсэг л байдаг.²⁹ гэснээс үзэхэд ухамсаргүй гэдэг ойлголт нь дотроо ухамсраас түрэгдсэн ой дурдатгалыг багтаахын зэрэгцээ “Ид” - ийг илэрхийлж байна.

Түүний үзлээр, түрэгдсэн зүйл нь түрэгдэлтийн эсрэг эсэргүүцлийн ачаар Би-гээс эрс онцгойрдог. Оно-ийн ачаар Би -тэй бас нийлэх бололцоотой болдог³⁰ гэжээ. Энд ухамсраас түрэгдсэн янз бүрийн ой дурдатгал нь ухамсаргүйн бүсэд байршиж, эргээд ухамсарт дарамт үзүүлж байгаа утгаараа ухамсраас эрс ялгарч, эсэргээрээ, ухамсаргүйн нэгэн хэсэг болж ухамсарт хүний үйл үйлдлийг чиглүүлж байдгаараа ухамсартай нийлэх бололцоо олддог гэж ойлгож байжээ. Дээр дурдсан ухамсаргүйн дүрээ хувиргасан хэлбэр болох хошигнол, хэл хальтирах, проекцийн жишээнүүд бол түрэгдсэн санаа бодлууд нь Ид -ийн ачаар ухамсарлагдаж байгаа дүрээ хувиргасан хэлбэр мөн гэж бид ойлгож байгаа болно.

Энэталаар бинь Оно-гийн нэгтөдийхөн бөгөөд... Оно-д дангаараа ноёрхогч дур ханамжийн зарчмыг бодит байдлын зарчимаар солихыг хичээж байдаг. Дур хүсэл Оно-гийн хувьд ямар ач холбогдолтой вэ, Би-гийн хувьд хүртэхүй нь яг л тийм ач холбогдолтой байдаг.³¹ гэж тэрээр үзэж байв. З.Фройдын задлан шижилснээр Оно буюу Ид нь хүний сэтгэцийг бүхэлд нь тодорхойлж байх бөгөөд харин Би буюу ухамсар-эго нь Оно-г өнгөлөн далдалсан өнгөц хэсэг нь гэж баталж байв.

Хүний үйл, үйлдэл дээр аваад үзвэл бидний ухамсартайгаар хийж байгаа бүх зүйл ухамсаргүйн гүнтэй харьцуулахад өчүүхэн хувийг эзэлдэг. Ухамсарт байдлаас нь хүний жинхэнэ мөн чанарыг танин мэдэж чадахгүй. Учир нь ухамсар нь мөн

чанараараа хүний жинхэнэ төрх байдлыг халхалсан өнгөлөн далдлалт байдаг гэж үзсэн юм. Гэхдээ ухамсар нь өнгөлөн далдлалт хийснээрээ бидний оршихуйг баталгаатай болгож аюул эрсдлээс хамгаалж байдгийг онцлон анхаарсан.

З.Фройд ухамсрын үүргийг, хүний үйл ажиллагаанд Би нь дур хүсэл агуулагч Оно-гийн эсрэг оюун ухаан, ухаалаг чанарыг билэгдэн байдаг. Би-гээс Оно-д буюу эго-гоос Ид-эд харьцах харьцааг адилтгаж үзвэл, Би нь агсам жороо морьтой, мориныхоо хүч явдлыг зээлдэн авсан хүчээрээ зохицуулах гэж хичээж байгаа бол Оно өөрийнхөө хүчээр мориныхоо чадлыг зохицуулах гэж мэрийхтэй эгээ л ижил юм. Энэхүү адилтгалыг цаашаа ч үргэлжлүүлж болох. Оно нь сайн мориноосоо салахыг хүсээгүй учраас мориныхоо аягыг дагах учиртай бол Би нь Оно-гийн дур зоргыг өөрийн дур зоргын асуудал мэтээр үзэж үйл ажиллагаандаа шилжүүлэн хувиргахын төлөө ажилладаг. Би нь төлөвшиж Оно /Тэр/-гоос тусгаарлагдана³² гэхчилэн зүйрлэсэн.

Эндээс үзвэл, ухамсаргүй нь байгалийн энерги бүхий төрөлхийн хүчийг агуулдаг, оюун ухаант хүнд байх амьтны инстинкийг илэрхийлдэг учраас өөрийн дур зоргыг илүүд үзэж, хэм хэмжээнд баригдахыг үл хүсдэг сэтгэцийн хамгийн хүчтэй энерги юм. Ухамсар-Би нь Ид-ийн энергийг бие организмынхаа хүчийг ашиглан зохицуулж хүнийг аюул, эрсдлээс хамгаалан хүний үйл ажиллагааг гадаад орчинтой нийцүүлэхийн төлөө ажиллаж байдаг механизм юм. Ийнхүү ухамсар нь сэтгэцийн амьдралд бага байр суурь эзэлдэг гэж үздэг хэдий ч хүний оршихуйг үргэлжилэх боломжоор хангаж байдгаараа бидний амьдралд ухамсар ихээхэн үүрэг гүйцэтгэдэг билээ.

Хүн, нийгмийн харилцаанд ёс зүйтэй, соёлтой мэт харагдахыг ямагт хичээж байдгийг хэлэхдээ, бид нийгмийн болон ёс зүйн үнэлгээг хаа сайгүй оруулаад сурчихсан улс. Ийм учраас Ид-ийн хүсэл тачаалын тоглоом ухамсарлагдаагүйн оронд болж буй гэдэгт нэг их гайхахгүй, гэхдээ сэтгэцийн үүрэг нь дээр өгүүлсэн үнэлгээ хичнээн өндөр байна, тэр хэмжээгээрээ ухамсарт хурдан хүрдэг. Гэтэл нэг талаас эрэгцүүлэл бясалгал шаардах

М.Баяртогтох. УБ., 2011. 143 дахь тал

²⁹ Мөн тэнд.

³⁰ Мөн тэнд.

³¹ Фрейд З. Ухамсаргүйн чанадал. Орч. Баатартогтох М, Бямбацогт Ц. УБ., 2015. 40 дэх тал

³² Мөн тэнд. 41 дэх тал

оюуны нарийн төвөгтэй ажил ухамсарт хүрэлгүйгээр ухамсарлагдаагүй нөхцөлд хийгдчихэж болох юм... унтаж байхад ч тохиолддог бөгөөд хүн сэрсэнийхээ дараа түрүүнд үр дүнгүй ноцолдсоор байсан математикийн болон өөр бусад хүнд бодлогуудын шийдлийг олчихсон байдгаар илэрдэг³³ “Би”-д буй хамгийн гүн гүнзгий төдийгүй шилмэл өндөр зүйлс ухамсарлагдаагүй байдаг байж болох юм гэдгийг бид үнэлэлт дүгнэлтийн хүрсэн хэмжээнээсээ зориуд тэмдэглэх ёстой³⁴ гэж ухамсаргүй интуицид танин мэдэхүйн ач холбогдол буйг онцолсон.

Бидний оюун ухаанаар танин мэдэж чадаагүй мэдлэгийн хариу зарим тохиолдолд ямар ч логик эрэгцүүлэл бодомж шаардахгүйгээр гэв гэнэт зөн билгээр ухамсарт хүртэгдэж болдог. Энэ бол интуицийн хүч гэж үзэж байна. Интуицээр танин мэдэгдсэн мэдлэг ухамсарт мэдлэгийн хамгийн гүн гүнзгий төдийгүй шилмэл өндөр мэдлэгийг бүтээж шинжлэх ухааны нээлт /Ньютоны татах хүчний онол/ болж болдгийг тэрээр олж тогтоосон юм. Нэгэн жишээ хэлэхэд, В.А.Моцартын хөгжмийн хөг аялгууг ухамсаргүйгээс мэдрэх мэдрэмж, хэрхэн ухамсарт хүртэгдэж болдог талаар өгүүлэхдээ: “Янз бүрийн хөгжмийн зэмсгийн дуу авианы тухай, эсрэг өнгөний тухай зэрэг бусад санаа бодлууд гарч ирэх яг тэр агшинд би өөрийн санааг олж авдаг. Энэ нь миний сэтгэлийг маш их хөвсөлзүүлэн хөдөлгөдөг бөгөөд хэрвээ надад хэн ч саад болохгүй байвал, чухам тэр үед маш их санаа бөөн бөөнөөрөө урган гарч ирээд би улам бүр асан дүрэлзэж, тэдгээр уран санаа уран сэтгэмжүүдийнхээ амин сүнснийг ухамсарладаг бөгөөд хэдийгээр бүдэг бадаг боловч бараг бүтнээрээ бэлэн болсон хөгжмийн зохиол миний толгой дотор жүжиг мэт харагдаж эхэлдэг. Ийнхүү эцэст нь би түүнийг өөрийн сэтгэл санаандаа яг л гайхамшигтай уран зураг юм уу үзэсгэлэн төгс хүний дүр төрх мэт ганц харцаар л эзэмдэн авч, гэнэт түүнийг бүх дүрслэлд нь ямар ч дэс дараалалгүйгээр бөөнд нь бүхлээр нь сонсдог. Бүх боловсруулалт, зохион бичих зэрэг нь надад яг л гайхамшигтай зүүд шиг болоод өнгөрдөг” гэжээ. Ухамсаргүйн

тухай З.Фройдын ойлголт нь урлаг, уран сайхны сэтгэлгээ, соёл, психоаналитик уран зохиолын хөгжилд ихээхэн хувь нэмрээ оруулсан.

З.Фройдын үзлээр, ухамсарлагдахгүй байгаа зүйлүүдээс бидний өдөр тутмын үйл ажиллагаа багагүй шалтгаалдаг. Ер нь хүний тархинд хадгалагдаж байгаа мэдээллийн өчүүхэн хувийг ухамсар хангадаг гэж тэр үзжээ. Үүнийгээ баталж “Бүхэлдээ ухамсрын хүрээнээс ангид оршдог түлхэц ба хөөрлүүд нь хүний зан үйлийн үнэхээр чухал хэсгүүдийг хэлбэршүүлэн чиглүүлдэг. Эдгээр нөлөө нь зүгээр л ухамсарлагдаагүй байж байдаггүй, ухамсарлагдаж эхлэх буюу зан үйлд ихээр гарч ирвэл хувь хүний хүчтэй дотоод эсэргүүцэлтэй тулгардаг. Хэдийгээр бүрэн ухамсарлагддаггүй боловч эдгээр далд санаа бодлууд нь хүний үйлдлүүдийг мэдэгдэхүйц тодорхойлж байдгаараа ухамсрын өмнөх түвшингээс ялгаатай юм”³⁵ гэж тэр бичжээ. Ухамсаргүй нь зүүд нойр, уран зөгнөл, тоглоом болон ажлын явцад дам байдлаар хангагдаж байдаг.

З.Фройдхүнийсэтгэцийнүйлажиллагаа бол ухамсаргүй ба ухамсарын хоорондын үл эвлэрэх тэмцэл, зөрчлийн талбар хэмээн тодорхойлжээ. Хүний уг чанарыг тайлбарлах үзэл хандлагууд дотроос содон, сонин хэрнээ үнэнийг хэлж чадсан түүний психоаналитик үзэл баримтлалын түлхүүр болж өгдөг ойлголтуудаас хамгийн үндсэн, түүний үзэл баримтлалын нь цөм болсон ойлголт бол “Ухамсаргүй” мөн. Хүний сайн, муу аливаа үйлдэл, үйл ажиллагаа, зан араншингийн олон янзын илрэлд төрөлхийн учир шалтгаан бүхий байгалийн хүчин зүйл байдгийг тэрээр нээж, тэрхүү ухамсаргүй эх үндсийг “Ид” гэж нэрлэсэн юм.

З.Фройдын психоаналитик баримтлалын агуулгыг нээж утгыг илэрхийлж байдаг олон ойлголтууд тухайлбал, түүний өөрийнх нь үзсэнээр хүний үйлдлийг тодорхойлж байдаг бэлгийн дур хүсэл бүхий энерги “либидо”, амьдралын өөдрөг инстинкт “эрос”, үхлийн зөн совин бүхий инстинкт “танатос”, либидогийн энергийн хувиргасан хэлбэр “сублимаци” болон бусад олон

³³ Фрейд З. Я и Оно. Академия. Ан ГССР . проф. Нанейшвили. Б.Р. Мерани веста 1991. с.368

³⁴ Там же

³⁵ Фрейд З. Зүүд. Орч. Баяртогтох М. УБ., 2002. 23 дахь тал

ойлголтоор илэрхийлэгдэж байгаа хүчин зүйлийн хамгийн анхдагч эх үндсийг тэмдэглэсэн ойлголт бол Ид юм. Хүний үйл ажиллагаанд ямар нэг байдлаар оролцож байдаг ухамсаргүйн энергийн илрэх олон хэлбэрийг зөв зохистой болгож, аюул болон ичгүүрээс сэргийлж байдаг хамгаалалтын механизм бол суперэго мөн. Хүний сэтгэцийн өргөн талбарт ухамсаргүй “Ид”, ухамсар эго хоёрын зөрчил идэвхтэй өрнөж байдаг бөгөөд эго идийн түлхэц хөөрлийг зохистой зарцуулан намжаахад бүх энергийг зарцуулж байна. Хүний сэтгэл зүйн зарим тохиолдолд “Ид” эго-д захирагдахгүй байх нь олонтоо байдаг.

Ид-ийн дарагдсан хүсэл, гадаад орчноос сэдэлтэй нийгэм болон хүний ёс суртахуун, хүн чанар хүлээж авах боломжгүй санаа бодол, дурдатгал, гомдол, айдас, түгшүүр, эмзэглэл, үзэн ядалт, жигшилт, хүлээлт зэрэг сэтгэл зүйн олон үзэгдэл хүний ухамсаргүйн бүсэд хадгалагдсан байх бөгөөд бид өөрөө ч эдгээрийг төдийлөн мэддэггүй гэж психоаналитикт үздэг. Ингэхлээр ухамсаргүйн бүс бол бидний нууцлаг, далд санаа бодлын агуулах сав болдог байна. Нэг үгээр хэлбэл юу хурааснаа сайн мэдэхгүй байгаа агуулах саваа цэвэрлэхтэй төстэйгээр хүн ухамсаргүйдээ хадгалсан элдэв санаа бодлоо гадагшлууж, цэвэрлэж байх нь бидний эрүүл мэндэд тустай аж. Ядаж л хэн нэгэнд гомдсон гомдлыг удаан хадгалж явснаас гадагш нь гаргаж, тайлж байх нь зүйтэй.

НОМ ЗҮЙ

1. Бие хүний онол дахь психодинамик чиг хандлага. Орч. О.Мягмар. УБ., 2001.
2. Ган-Өлзий Ч. Эдүгээгийн философид эргэн орохуй. УБ., 2007.
3. Дарьхүү Р. Дорнын болон өрнийн философи дахь хүний асуудал. УБ., 1996
4. Дарьхүү Р. Фрейдизм дэх хүний сэтгэцийн үйл ажиллагааны тухай асуудалд МУИС. НУФ. Эрдэм шинжилгээний бичиг. №6 /150/. УБ., 2000
5. Жостейн Гаардер. Софийн ертөнц. Орч. Б. Мөнхжавхлан. УБ., 2013
6. Лосский Н.О. Чувственная, интеллектуальная и мистическая интуиция

М., 1999

7. Отгонбаяр Ж. Нэмэхжаргал Т. Ширээн дээрх бичсэн текстийн тухай эрэгцүүлэл. МУИС. ЭШБ, Философи шашин судлал №271(37) УБ., 2007. х 110
8. Фрейд З. Зохиолууд. Психоанализ. УБ., 2011.
9. Фрейд З. Зохиолууд. Зүүд. УБ., 2011.
10. Фрейд Зигмунд. Пять лекций о психоанализе. СПб., 1999.
11. Фрейд З. Я и Оно. Академия ГССР . проф. Нанейшвили. Б.Р. Мерани веста 1991
12. Фрейд З. Ухамсаргүйн чанадад. Орч. Баатартогтох М, Бямбацогт Ц. УБ., 2015
13. The Basic Writings of Sigmund Freud, Dr. A. A. Brill, NY, 1938

ABSTRACT

Sigmund Freud's psychoanalytic theory of personality argues that human behavior is the result of the interactions among three component parts of the mind: the id, ego, and superego. This theory, known as Freud's structural theory of personality, places great emphasis on the role of unconscious psychological conflicts in shaping behavior and personality. People are in endless conflict. Sources of conflict are linked to human mental unconscious. Our lives no managing by conscious, has ruled natural. The unconscious spur impulse is expressed that concept “Id” in psychoanalytic theory. “Id” is a human life in part always guide our actions and behavior in a variety but also affect a significant role in society and cultural world.